

<b>Асуулт</b>	<b>Хариулт</b>
<p><b>A.1</b> Битүүмжилсэн цаасан эх хувийг хүргүүлэхийн тулд Монгол улсруу биечлэн төлөөлөгч илгээх шаардлагатай эсэх, эсвэл шуудан/каргоор илгээж болох эсэхийг тодруулж өгнө үү.</p>	<p><b>X.1</b> Битүүмжилсэн цаасан эх хувийг илгээхдээ шуурхай хүргэлтийн үйлчилгээ (жишээлбэл, DHL эсвэл EMS)-г ашиглаж болно. Баримт бичгүүдийг 5 дугаар сарын 11-ний өдрөөс өмнө заавал хүргүүлнэ үү.</p>
<p><b>A.2</b>  Баримт бичигт дурдсан “үйлдвэрийн менежментийн системийн талаарх мэдээлэл” гэсэн нэр томъёоны утгыг тодруулж өгнө үү. Мөн үүнд ямар агуулга багтах ёстой талаар жишээ өгч тайлбарлаж өгнө үү.</p>	<p><b>X.2</b> Үйлдвэрийн үйл ажиллагааг хянах, хяналт тавих, оновчлох зорилгоор ашиглаж буй зохион байгуулалтын системүүдийн талаарх тайлбарыг ирүүлнэ үү. Үүнд дараах зүйлсийг багтааж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй: • Үйлдвэрлэлийн удирдлагын систем • Эрчим хүчний менежментийн систем • Засвар үйлчилгээний менежментийн систем • Нөөц болон материалын удирдлагын систем • Бодит цагийн хяналтын систем • Чанарын удирдлагын систем г.м</p>
<p><b>A.3</b> Хэрэв бид албан ёсны төрийн байгууллагын вэбсайтаас татаж авсан холбогдох хуудсуудын PDF хувийг зөвхөн нотлох баримт болгон ирүүлбэл, үүнийг хүчинтэйд тооцох уу?</p>	<p><b>X.3</b> Хэрэв мэдээлэл нь танай компани хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулдаг эсэхийг баталгаажуулах боломжтой нээлттэй, албан эх сурвалжаас авсан бол тухайн мэдээллийн PDF хувилбарыг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрнө</p>
<p><b>A.4</b> Танай зүгээс тендерийн баримт бичгийн бүрдлийг үнэн зөв эсэхийг шалгах мөн ямар нэгэн алдаа байгаа эсэхийг шалгах зорилгоор аливаа нэг хүн эсвэл баг ажиллуулж байгаа талаар тодруулж өгнө үү Жишээлбэл, бид 5-р сарын 5-ны өдөр тендерийн баримт бичгийн төслийг урьдчилсан байдлаар илгээхээр төлөвлөж байгаа бөгөөд уг баримт бичгийг та болон танай хамт олон хянаж, аливаа алдаа, дутуу мэдээлэл байвал бидэнд мэдэгдэх боломжтой юу? Ингэснээр бид албан ёсны хугацаанаас өмнө шаардлагатай засвар,</p>	<p><b>X.4</b> Таны гаргасан хүсэлт нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх боломжтой тул урьдчилан бэлтгэсэн баримт бичгийг хянах ажилтныг томилох боломжгүй. Өргөдөл гаргагчид баримт бичгээ тогтоосон удирдамжийн дагуу нарийн мөрдөж бэлтгэн, илгээх үүрэгтэй. Хэрэв удирдамжийн аль нэг хэсэгт тодруулга шаардлагатай бол бүх оролцогчдод тэгш мэдээлэл хүргэх үүднээс манай яамны албан ёсны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> цахим хуудсанд байршуулсан сонгон шалгаруулалтын зар тавигдсан хэсэгт хавсаргагдах болно.</p>

<p>сайжруулалтыг хийх хангалттай хугацаатай байх юм.</p>	
<p><b>A.5</b> Төсөл хэрэгжүүлэх байршил Дархан-Уул аймгийн Орхон сумын нутагт байрлах 651 га талбай бүхий үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрт гэсэн байна. Энэ газрын эрх нь төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан байгууллагатай хамтарсан компанийн эзэмшилд шилжих үү?</p>	<p><b>X.5</b> Стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах баримт бичгийн 4.2 дугаар зүйлд заасны дагуу сонгогдсон компанитай хийх хэлэлцээрийн явцад, тэдгээрийн санал болгож буй хөрөнгө оруулалтын нөхцөлтэй уялдуулан газар ашиглалттай холбоотой асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.</p>
<p><b>A.6</b> Газар эзэмших эрхийн хугацаа ямар хугацаагаар тухайн компани дээр шилжих вэ?</p>	<p><b>X.6</b> Уг асуудлыг мөн хэлэлцээрийн явцад талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.</p>
<p><b>A.7</b>  Төсөл хэрэгжүүлэх газарт хэрэглээний зардлууд ямар үнэтэй байдаг вэ? Цахилгааны үнэ?</p>	<p><b>X.7</b> Төвийн эрчим хүчнээс ашиглаж буй эрчим хүчний үнийг дараах байдлаар тооцдог. Өдрийн хэрэглээ /06.00 цагаас 17.00 цаг хүртэл/ 285 төг/квт.ц Оройн хэрэглээ /17.00 цагаас 22.00 цаг хүртэл/ 476 төг/квт.цаг Шөнийн хэрэглээ /22.00 цагаас 06.00 цаг хүртэл/ 160 төг/квт.цаг Хэрэв хөрөнгө оруулагч нь өөрийн эрчим хүчний эх үүсвэрийг барих буюу төвийн эрчим хүчтэй холбогдоогүй нөхцөлд өөрийн үйлдвэрлэлийн өртөгөөр хэрэглэх боломжтой.</p>
<p><b>A.8</b>  Хэрэглээний усны үнэ?</p>	<p><b>X.8</b> Усны төлбөрийг тооцохдоо ямар эх үүсвэрийн ус ашиглаж байгаагаас хамаарч өөр өөрөөр тогтоогддог. Ундны усны зориулалтаар ашиглаж байгаа тохиолдолд /Гадаргын ус 1113 төгрөг/м3, Газрын гүний ус 989 төгрөг/м3/ Үйлдвэрлэлийн зориулалтаар бол /Гадаргын ус 83.5 төгрөг/м3, Гүний ус 197 төгрөг/м3/ Хэрэв үйлдвэрлэлд саарал ус ашиглах бол усны хэрэглээний хэдэн хувьд</p>

	ашиглаж байгаагаас хамаарч тухайн хувь хэмжээгээр төлбөрөөс хөнгөлнө.
<b>A.9</b> Шатамхай хийн үнэ /газ/ ?	<b>X.9</b> Монгол Улсад одоогоор үйлдвэрлэлд шатамхай хийг түгээмэл ашигладаггүй учир тогтсон үнэ гаргахад хүндрэлтэй байна.
<b>A.10</b> Татварын мэдээлэл /Газрын төлбөрөөс 10 жилийн хугацаанд чөлөөлнө. ✓ Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг эхний 5 жилд 100 хувь, дараагийн таван жилд 50 хувь хөнгөлнө. ✓ Гадаад ажилчдын ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлнө./ гэсэн байна. Газрын төлбөр нь чөлөөлөөгүй тохиолдолд одоогийн үнэ ханшаар тооцож үзвэл хэдэн төгрөгийн татвар чөлөөлөгдөхөөр байгаа вэ?	<b>X.10</b>  1 жилд төлөгдөх газрын төлбөр нь зориулалтаас хамаарч 1 га тутамд 80000-1280000 төгрөг байна.
<b>A.11</b> Үл хөдлөх эд хөрөнгийн татвар дээрхийн мөн адил хэдэн төгрөг болох?	<b>X.11</b> Жил бүр үл хөдлөх хөрөнгийн нийт дүнгээс 2%-р тооцож татвар ноогдуулдаг.
<b>A.12</b>  Гадаад ажилчдын ажлын байрны төлбөр мөн хэдэн төгрөг 1 ажилтанд байх талаар мэдээлэл өгч тусална уу.	<b>X.12</b> Монгол Улсын хууль журмын дагуу 1 гадаад ажилтанд сар тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөрийг ноогдуулдаг. 2026 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792000 төгрөг буюу 1 сард 1 ажилтан тутамд 1584000 төгрөг төлөхөөр байна.
<b>A.13</b> Бид таны системийн 32 МБ хэмжээний хязгаарлалтын улмаас файлуудыг имэйлээр илгээх боломжгүй байна. Нийт илгээх материал 600 МБ бөгөөд үүнд 275 МБ хэмжээтэй нэг баримт бичиг багтаж байгаа бөгөөд үүнийг хэсэгчилж хуваах эсвэл тусад нь илгээх боломжгүй юм. Иймд эдгээр баримт бичгийг илгээх өөр боломжит арга (жишээлбэл, аюулгүй	<b>X.13</b> Тендерийн баримт бичгийн нууцлалыг хангах үүднээс бид дараах аргуудын аль нэгийг ашиглахыг зөвлөж байна: ➤ Нууц үгээр хамгаалагдсан архив: Файлуудаа 7-Zip эсвэл WinRAR программ ашиглан AES-256 шифрлэлтээр нууц үг хийж архивлахыг хүсье. Үүний дараа нууцлагдсан архиваа өөрийн сонгосон файл дамжуулах

<p>файл дамжуулах линк эсвэл FTP хандалт) санал болгож өгөхийг хүсье.</p>	<p>платформд байршуулан холбоосыг (link) бидэнд илгээж болно.</p> <ul style="list-style-type: none"><li>➤ Аюулгүй файл дамжуулах үйлчилгээ: Хэрэв та WeTransfer Pro, TransferNow эсвэл Proton Drive зэрэг платформуудыг ашигладаг бол татах холбоосоо (link) нууц үгээр хамгаалж идэвхжүүлнэ үү.</li></ul> <p>Аюулгүй байдлын үүднээс, файл хуулагдаж дууссаны дараа нэвтрэх нууц үг эсвэл кодыг тусад нь өөр сувгаар (Линк болон нууц үгийг тус имэйл рүү илгээнэ үү: <a href="mailto:industry@mmhi.gov.mn">industry@mmhi.gov.mn</a>)</p>
---	--